



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2024/07-НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.com">Narantsetsegba@audit.gov.com</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-21
4. Аудитын тайлан	21-25
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	25-30
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	31-32

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОХНС	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх
ЗА	Захирагчийн алба
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭЭГБХТэмцэх	Хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, гэр бүлийг хамгаалах, тэмцэх
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТХС	Санхүү, төрийн сангийн хэлтэс



МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
А.ДАШЗЭВЭГ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № САА-2024/07-НАСТАВИЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оноос сумын Спортын ордны санхүүжилтийг аймгийн БТСГ-т шилжүүлэн, санхүүгийн тайлан тус газарт нэгтгэгдэж байна. Гэвч Спортын ордны хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гараагүйгээс тус газрын эзэмшилд буй 28,626.7 мянган төгрөгийн бараа материал, 995,084.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, тайлагнагдсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 124 дүгээр тогтоолоор Мандал сум нь тайлант онд 7,364,788.5 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн

төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 9,093,606.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 123.5 хувиар биелүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Мандал суманд их хэмжээний хүчтэй бороо орсны улмаас үер бууж, далан, гүүр эвдэрсэн зэргээс Засаг даргын нөөц хөрөнгөөс 137,683.8 мянган төгрөгийг, сумын ОНХС-аас 197,906.0 мянган төгрөгийг тус тус гамшгийн зардалд зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайл ан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,349,826.50</b>	<b>8,054,743.00</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,674,521.40	3,462,978.30
33	АВЛАГА	951,709.80	885,495.80
35	БАРАА МАТЕРИАЛ	2,723,595.30	3,706,268.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,126,121.10</b>	<b>17,171,165.60</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,126,121.00	17,171,165.60
39200	Биет хөрөнгө	14,513,193.40	16,559,278.30
39300	Биет бус хөрөнгө	612,927.70	611,887.30
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>22,475,947.60</b>	<b>25,225,908.60</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>251,765.60</b>	<b>229,439.90</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	251,765.60	229,439.90
41300	Өглөг	251,765.60	229,439.90
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>22,224,182.00</b>	<b>24,996,468.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>22,224,182.00</b>	<b>24,996,468.70</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,107,916.90	6,107,916.90
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>14,531,296.90</b>	<b>17,303,583.60</b>
<b>51300</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>1,584,968.20</b>	<b>1,584,968.20</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>22,475,947.60</b>	<b>25,225,908.60</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>13,450,343.20</b>	<b>17,157,343.40</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>8,002,393.60</b>	<b>8,307,811.90</b>
110	Орлогын албан татвар	4,859,183.70	6,418,999.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,859,183.70	6,835,111.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.00	-416,112.40
113	Хөрөнгийн албан татвар	587,986.60	821,828.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,555,223.20	1,066,984.30
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,268,322.60</b>	<b>5,638,092.50</b>
120	Нийтлэг татварын бус орлого	2,268,322.60	5,638,092.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,179,627.00</b>	<b>3,211,438.90</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,679,200.50</b>	<b>9,595,761.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,588,341.20</b>	<b>9,595,761.60</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,585,900.30	7,347,831.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,509,225.60	1,871,554.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,262.00	231,859.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,564,948.40	230,688.20
2104	Хангамж, бараа материалын зардал	125,835.90	192,809.00
2105	Нормативт зардал	2,971.10	173.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	392,963.00	166,555.10
2107	Томилолт, зочны зардал	7,746.00	11,881.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,088,308.40	3,772,692.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	707,639.60	869,618.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,002,440.90	2,247,929.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,090,859.30	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>4,771,142.80</b>	<b>7,561,581.80</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>29,507,038.30</b>	<b>4,780,095.20</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-24,735,895.60</b>	<b>2,781,486.60</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>12,344,645.40</b>	<b>12,749,962.90</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>8,002,393.60</b>	<b>8,307,811.90</b>
110	Орлогын албан татвар	4,859,183.70	6,418,999.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	4,859,183.70	6,835,111.80
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.00	-416,112.40
113	Хөрөнгийн албан татвар	587,986.60	821,828.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,555,223.20	1,066,984.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	346,943.00	294,481.10
1181	Газрын төлбөр	586,232.40	487,925.60
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,622,047.90	284,577.60
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,038,688.60</b>	<b>1,123,741.50</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,038,688.60	1,123,741.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,303,563.20	3,318,409.50
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,348,496.50</b>	<b>8,865,799.10</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,348,496.50	8,865,799.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,317,851.20	6,617,261.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,509,082.90	1,871,554.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,288.80	231,859.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,564,948.40	232,188.20
2104	Хангамж, бараа материалын зардал	104,644.40	206,371.70
2105	Нормативт зардал	1,893.00	443
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	424,369.40	187,210.80
2107	Томилолт, зочны зардал	7,746.00	9,529.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,055,045.90	3,801,788.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	463,832.40	76,317.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,030,645.30	2,248,537.40
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,996,148.80</b>	<b>3,884,163.80</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>4,510,653.60</b>	<b>3,880,706.90</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,510,653.60	3,880,706.90
2200	Дотоод эх үүсвэрээр	4,510,653.60	3,880,706.90
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-4,510,653.60</b>	<b>-3,880,706.90</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-230,000.00</b>	<b>-215,000.00</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	230,000.00	215,000.00
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>255,495.20</b>	<b>-211,543.10</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,419,026.20	3,674,521.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,674,521.40	3,462,978.30

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>47,403,466.30</b>	<b>0.0</b>	<b>47,403,466.30</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-12,114,376.20	0.0	-12,114,376.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>35,289,090.10</b>	<b>0.0</b>	<b>35,289,090.10</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
7	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
8	Тайлант үеийн үр дүн	-24,735,895.60	0.0	-24,735,895.60
9	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>22,224,182.00</b>	<b>0.0</b>	<b>22,224,182.00</b>
10	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>22,224,182.00</b>	<b>0.0</b>	<b>22,224,182.00</b>
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,199.9	0.0	-9,199.9
12	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>22,214,982.1</b>	<b>0.0</b>	<b>22,214,982.1</b>
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
16	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
17	Тайлант үеийн үр дүн	2,781,486.6	0.0	2,781,486.6
18	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>24,996,468.7</b>	<b>0.0</b>	<b>24,996,468.7</b>

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,052,991.60</b>	<b>10,670,580.86</b>	<b>1,382,410.74</b>	<b>88.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,063,822.90</b>	<b>6,708,416.63</b>	<b>355,406.27</b>	<b>95.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,996,165.60</b>	<b>6,655,509.20</b>	<b>340,656.40</b>	<b>95.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,938,079.30	1,868,249.01	69,830.29	96.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	242,486.30	231,858.98	10,627.32	95.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,220,087.80	2,100,074.06	120,013.74	94.6
2104	Хангамж, бараа материалын зардал	191,159.80	181,021.41	10,138.39	94.7
2105	Нормативт зардал	564.10	443.00	121.10	78.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	602,633.60	596,213.48	6,420.12	98.9
2107	Томилолт, зочны зардал	11,694.90	9,529.60	2,165.30	81.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,718,124.00	1,599,360.21	118,763.79	93.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,335.80	68,759.45	2,576.35	96.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>67,657.30</b>	<b>52,907.43</b>	<b>14,749.87</b>	<b>78.2</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,549,218.70</b>	<b>3,747,164.23</b>	<b>802,054.47</b>	<b>82.4</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>439,950.00</b>	<b>215,000.00</b>	<b>224,950.00</b>	<b>48.9</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>12,052,991.60</b>	<b>11,094,164.55</b>	<b>958,827.05</b>	<b>92.0</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>8,267,270.00</b>	<b>10,700,206.77</b>	<b>-2,432,936.77</b>	<b>129.4</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,785,721.60</b>	<b>393,957.78</b>	<b>3,391,763.82</b>	<b>10.4</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	400,265.28	-400,265.28	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	823,848.96	-823,848.96	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>185</b>	<b>185</b>	<b>185</b>	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>90</b>	<b>90</b>	<b>90</b>	<b>100.0</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>415,070.28</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>415,070.28</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>92,295.15</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,305.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,350.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,359.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	18,722.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,557.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>319,775.13</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	319,775.13
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>415,070.28</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	<b>415,070.28</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Мандал сумын ТТЗ гэх/ нь 2023 оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүнээ дээдэлж, үйлдвэрлэлтийг дэмжиж хамтын хүчээр сумаа хөгжүүлье” гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилтын хүрээнд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Төр иргэний харилцан итгэлцлийг хангасан чадварлаг засаглалын бодлогыг хэрэгжүүлэх,
- Иргэн бүрийг хөдөлмөрлөх ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулах,
- Орон нутгийн түүхий эдийн бааз суурь дээр тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх гэх мэт.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ,
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлөгдөх, хяналт тавих журамд ХХААХҮ-ийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ны А/521 тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/450 дугаар тушаалаар “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ыг шинэчлэн баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2023 онд Мандал сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,749,961.0 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,674,521.4	3,462,978.3	-211,543.1
Авлага	951,709.8	885,495.8	-66,214.0
Бараа материал	2,723,595.3	3,706,268.9	982,673.6
Үндсэн хөрөнгө	15,126,121.1	17,171,165.6	2,045,044.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>22,475,947.6</b>	<b>25,225,908.6</b>	<b>2,749,961.0</b>
Өр төлбөр	251,765.6	229,439.9	-22,325.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	22,224,182.0	24,996,468.7	2,772,286.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>22,475,947.6</b>	<b>25,225,908.6</b>	<b>2,749,961.0</b>

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн үлдэгдэл 25,225,908.6 мянган төгрөг болж, 2,749,961.0 мянган төгрөгөөр өссөн нь аймаг, сумын ОНХО болон ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 3,674,521.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,462,978.3 мянган төгрөг болж, 211,543.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	3,674,521.4	3,462,978.3	-211,543.1
<b>Дүн</b>	<b>3,674,521.4</b>	<b>3,462,978.3</b>	<b>-211,543.1</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНХО-ын дансанд 2,560,033.8 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 583,872.2 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 239,976.8 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний дансанд

79,095.5 мянган төгрөг зэрэг нийт 3,462,978.3 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 951,709.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 885,495.8 мянган төгрөг болж, 66,214.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст олгосон зээл	910,673.9	850,219.3	-60,454.6
Зээлийн хүүгийн авлага	41,035.9	35,276.5	5,759.4
<b>Дүн</b>	<b>951,709.8</b>	<b>885,495.8</b>	<b>-66,214.0</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд ХХС-тай холбоотой зээлийн 850,219.3 мянган төгрөг, зээлийн хүүгийн 35,276.5 мянган төгрөг зэрэг нийт 885,495.8 мянган төгрөгийн авлага тус тус тайлагнагдсан байна. Нийт авлагаас хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг тодруулбал:

- ✓ 2008-2020 оны үндсэн зээлийн авлагын 419,158.8 мянган төгрөгийн, зээлийн хүүгийн авлагын 22,393.5 мянган төгрөгийн зэрэг нийт 441,552.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн авлага бүртгэлтэй байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 2,723,595.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,706,268.9 мянган төгрөг болж, 982,673.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	4,184.7	15,077.8	10,893.1
Эм боох материал	127.5	127.5	0.0
Бичиг хэргийн материал	5,033.9	6,402.2	1,368.3
Аж ахуйн материал	45,707.5	47,205.6	1,498.1
Барилгын засварын материал	22,918.0	34,934.5	12,016.5
Бусад хангамжийн материал	2,643,268.7	3,560,121.9	916,853.2
Сэлбэг хэрэгсэл	2,355.0	10,999.4	8,644.4
Мал амьтад	0.0	31,400.0	31,400.0
<b>Дүн</b>	<b>2,723,595.3</b>	<b>3,706,268.9</b>	<b>982,673.6</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 982,673.6 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 3,706,509.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, дээд шатны байгууллагаас 35,533.4 мянган төгрөгийн мал амьтан, шатахуун, сэлбэг хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 1,015,557.8 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн,
- 546,574.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 3,228,352.8 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг бараа материалын дансаар дамжуулан ашиглагч байгууллагуудад тус тус шилжүүлсэн гэх мэт.

#### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 15,126,121.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 17,171,165.6 мянган төгрөг болж, 2,045,044.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	6,974,671.4	7,476,526.3	501,855.0
Авто-тээврийн хэрэгсэл	184,364.4	323,399.4	139,035.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	621,294.9	763,381.6	142,086.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	92,820.3	128,910.5	36,090.2
Зам, гүүрийн байгууламж	3,455,846.4	5,562,560.1	2,106,713.7
Дуусаагүй барилга байгууламж	2,704,079.0	1,438,103.2	-1,265,975.9
Бусад үндсэн хөрөнгө	479,666.0	865,946.2	386,280.2
Ном	451.0	451.0	0.0
Программ хангамж	3,070.0	2,255.0	-815.0
Бусад биет бус хөрөнгө	609,857.7	609,632.3	-225.4
<b>Дүн</b>	<b>15,126,121.1</b>	<b>17,171,165.6</b>	<b>2,045,044.5</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,045,044.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 813,537.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хандиваар 500,277.7 мянган төгрөгийн барилга, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авсан, аймаг, сумын ОНХС-ийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,122,020.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, 30,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, балансаас балансад 1,605,068.1 мянган төгрөгийг шилжүүлсэн болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 20,019.5 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, бүртгэсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд 1,438,103.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- Тарнийн 8 дугаар багийн барилгын 40,000.0 мянган төгрөгийн /цэвдэгтэй газар баригдаад улсын комисс ашиглалтад хүлээж аваагүйгээс/,

- Түнхэл тосгоны төрийн албан хаагчийн байр болон соёл спортын цогцолборын барилгын 1,078,366.4 мянган төгрөгийн /Барилгын хөгжлийн төвөөс зөвшөөрөл гараагүйгээс улсын комисс хүлээж аваагүй байна/ ,

- ЗДТГ-ын 3-р багийн тоглоомын талбайн 319,736.8 мянган төгрөгийн /гэрээт ажил тайлант онд хийгдэж дуусаагүй, он дамжин хэрэгжсэн/ дуусаагүй барилга тус тус бүртгэлтэй байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 251,765.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 229,439.9 мянган төгрөг болж, 22,325.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	251,070.5	229,439.9	-21,630.6
Хувь хүмүүст төлөх өглөг	695.1	0.0	-695.1
<b>Дүн</b>	<b>251,765.6</b>	<b>229,439.9</b>	<b>-22,325.7</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөрийн үлдэгдэлд: зам засварын үлдэгдэл санхүүжилтийн байгууллагад төлөх өглөгийн 29,206.9 мянган төгрөг, ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын барьцаа 200,233.0 мянган төгрөгийн зэрэг өр төлбөр тус тус тайлагнагдсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 22,224,182.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 24,996,468.7 мянган төгрөг болж, 2,772,286.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,107,916.9	6,107,916.9	0.0
Хуримтлагдсан үр дүн	14,531,296.9	17,303,583.6	2,772,286.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,584,968.2	1,584,968.2	0.0
<b>Дүн</b>	<b>22,224,182.0</b>	<b>24,996,468.7</b>	<b>2,772,286.7</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 124 дүгээр тогтоолоор Мандал сум нь тайлант онд 7,364,788.5 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 9,093,606.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 123.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/					
д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	4,680,493.0	5,798,357.5	1,117,864.5	123.9
2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-416,112.5	-416,112.4	0.1	100.0
3	Үйл ажиллагааны орлого	230,000.0	367,273.9	137,273.9	159.7
4	Хөрөнгийн татвар	195,000.0	239,179.0	44,179.0	122.7
5	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	590,000.0	539,894.6	-50,105.4	91.5
6	Хадгаламжийн хүүгийн орлого	320,000.0	430,301.4	110,301.4	134.5
	Бууны албан татвар	13,000.0	13,769.0	769.0	105.9
7	Улсын тэмдэгтийн хураамж	88,000.0	71,678.4	-16,321.6	81.5
8	Газрын төлбөр	300,000.0	341,547.1	41,547.1	113.8
9	Дуудлага худалдааны орлого	100,000.0	146,378.5	46,378.5	146.4
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	32,000.0	72,197.1	40,197.1	225.6
11	Ус ашигласны төлбөр	5,000.0	5,940.6	940.6	118.8
12	Ойн нөөц ашигласны төлбөр	213,290.0	274,237.9	60,947.9	128.6
13	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,142.0	1,469.5	-672.5	68.6
14	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,000.0	2,929.6	1,929.6	293.0
15	Малын тоо толгойн албан татвар	240,976.0	268,164.6	27,188.6	111.3
16	Хог хаягдлын хураамжийн орлого	150,000.0	150,605.6	605.6	100.4
17	Бусад орлого	120,000.0	319,481.8	199,481.8	266.2
18	Хүү, торгуулийн орлого	500,000.0	466,312.5	-33,687.5	93.3
	<b>Нийт дүн</b>	<b>7,364,788.5</b>	<b>9,093,606.2</b>	<b>1,728,817.7</b>	<b>123.5</b>

Орлогын төлөвлөгөө 1,728,817.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн

орлогын албан татвар, үйл ажиллагааны, хадгаламжийн хүүгийн болон ойн нөөц ашигласны төлбөр зэрэг орлогууд тус тус төлөвлөгөөнөөс давсантай холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### Давсан орлого

- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 60,947.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газраас бэлтгэх модны болон хуш модны самар бэлтгэх гэрээ хийгдсэнтэй холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 110,301.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь суманд орлого төвлөрдөг болсонтой холбоотой байна.
- Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 1,117,864.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой байна.

#### Тасарсан орлого:

- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 50,105.4 мянган төгрөгөөр тасарсан нь орлогыг хэт өндрөөр төлөвлөснөөс,
- Улсын тэмдэгтийн хураамж 16,321.6 мянган төгрөгөөр тасарсан нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын шүүхээр шийдвэрлүүлсэн маргаантай холбоотой,
- Хүү, торгуулийн орлого 33,687.5 мянган төгрөгөөр тасарсан нь сумын зөрчлийн хэмжээ буурсан зэргээс тус тус шалтгаалсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 11,306,525.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 85 дугаар тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 6,700,408.0 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 64,500.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 1,813,752.4 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 2,595,813.0 мянган төгрөг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 132,052.5 мянган төгрөг,
- ХХС-ийн 451,000.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **11,757,525.9** мянган төгрөг, зарлагыг **10,061,896.0** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт **1,695,629.9** мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 664,380.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 7,364,788.5 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 64,500.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 3,038,221.6 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,098,111.5 мянган төгрөг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 232,078.4 мянган төгрөг,
- ХХС-ийн 451,000.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **14,248,621.6** мянган төгрөг, зарлагыг **12,052,991.6** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг **2,195,630.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогыг 9,093,606.2 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 106,151.6 мянган төгрөгөөр, ХХС-ийн эргэн төлөлтийн 287,806.2 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,098,111.5 мянган төгрөгөөр зэрэг нийт **13,258,557.2** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, **2,195,630.0** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **10,670,580.8** мянган төгрөг буюу 88.5 хувьтай тайлагнагдсан нь ХХС-ийн зээл болон ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна. Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- ✓ Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 69,830.3 мянган төгрөгөөр,
- ✓ Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 10,627.3 мянган төгрөгөөр,
- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 120,013.7 мянган төгрөгөөр,
- ✓ Хангамж, бараа материалын зардал 10,138.4 мянган төгрөгөөр,
- ✓ Нормативт зардал 121.1 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардал 6,420.1 мянган төгрөгөөр,
- ✓ Албан томилолтын зардал 2,165.3 мянган төгрөгөөр,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 118,763.8 мянган төгрөгөөр,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардал 2,576.4 мянган төгрөгөөр,
- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 14,749.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 14 төсөл, арга хэмжээнд 1,053,631.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр

792,259.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 261,372.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, Тарни 8-р багт дэд станц барих, 12 айлын зам талын 2 байрны фасад засвар, Түнхэл тосгоны тоглоомын талбайн болон 1,3 км зам барих зэрэг ажлууд нь хэрэгжиж дуусаагүй он дамжсан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 20 төсөл, арга хэмжээнд 3,538,776.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 2,954,904.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 463,101.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 3 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, Тултын тохойн гүүрний ажил гүйцэтгэгч компаниас шалтгаалан хэрэгжиж дуусаагүй болон 9 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай барих ажил дууссан боловч улсын комисс ажиллаагүй, хүлээн аваагүй зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 329,711.2 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 3,000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллого болон судалгааны ажлын 5,245.0 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулганы арга хэмжээний 1,800.0 мянган төгрөг, ХЭЭГБХТэмцэх төслөөс 4,830.0 мянган төгрөг, Хөдөө аж ахуйн экосистемийн тогтвортой байдлыг хангах төслөөс ойн арчилгаа, огтлолт хийх ажлын зардалд 1,829.9 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 32,067.2 мянган төгрөг, үерийн гамшигтай холбоотойгоор иргэдээс 9,835.0 мянган төгрөгийн, аж ахуйн нэгж байгууллагаас буюу “ДМС трейд” ХХК-аас 26,700.0 мянган төгрөгийн, Төрийн банкнаас 52.0 мянган төгрөгийн нийт 36,587.0 мянган төгрөгийн хандив тусламж зэрэг нийт **415,070.3** мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс:

- ✓ Цалин хөлсөнд 3,305.0 мянган төгрөг,
- ✓ Хангамж бараа материалын зардалд 25,350.3 мянган төгрөг,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардалд 40,359.9 мянган төгрөг,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 18,722.3 мянган төгрөг,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 7,557.7 мянган төгрөг зэрэг нийт **95,295.2** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 319,775.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд аймаг, сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн харьцуулалт болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 26 төсөл, арга хэмжээний /1 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй/ худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга		НША	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Аймгийн ХО	7	1,062,031.9	4	242,829.0	3	819,202.9
Сумын ОНХО	5	699,278.5	2	139,578.5	3	559,700.0
Сумын ОНХС	13	3,272,568.5	5	253,351.3	7	2,519,217.2
<b>Нийт дүн</b>	<b>25</b>	<b>5,033,878.9</b>	<b>11</b>	<b>635,758.8</b>	<b>13</b>	<b>3,898,120.1</b>

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч цаашид /Мандал сумын ТТЗ гэх/-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт болон татварын тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/167 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн

нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 8,679,200.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 86,792.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт орсон тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 9,595,761.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **95,957.6** мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зардлуудыг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 120,013.7 мянган төгрөгөөр,
- ✓ Хангамж, бараа материалын зардлыг 10,138.4 мянган төгрөгөөр,
- ✓ Бичиг хэргийн зардлыг 2,361.5 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил худалдан авах зардлыг 6,420.1 мянган төгрөгөөр,
- ✓ Албан томилолтын зардлыг 2,165.3 мянган төгрөгөөр,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 118,763.8 мянган төгрөгөөр гэх мэт.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 49 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад ЗДТГ-т дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ Үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-ын зардлаас сэтгүүл, урилга хэвлүүлэхэд 2,649.0 мянган төгрөгийг */сэтгүүл 100 ширхгийг 16250 төгрөгөөр, урилга 200 ширхгийг 5120 төгрөгөөр/*, сумын танилцуулга видео хийлгэхэд 2,000.0 мянган төгрөгийг тус тус олгосон,
- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас байгууллагын дотоод журамд заасны дагуу тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж байгаа гэх үндэслэлээр 22 албан хаагчид нийт 11,200.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс Спирт бал бурам ХК-ийн 50 жилийн ойн арга хэмжээнд 1,720.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн гэх мэт.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан

таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 9. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт*

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	ТТЗ	145	138	5	
2	Засаг даргын тамгын газар	171	170	1	
3	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	170	1	
4	Хэрх тосгоны Захирагчийн алба	171	169	2	
5	Түнхэл тосгоны Захирагчийн алба	171	170	1	
6	Ойн анги	171	170	1	
7	Хүүхдийн ордон	171	170	1	
	<b>Нийт дүн</b>	<b>1171</b>	<b>1157</b>	<b>12</b>	

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Худалдан авах ажиллагаа:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төсвөөс хөрөнгө худалдан авахдаа босго үнийн журмыг хэрэгжүүлээгүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Эрүүл иргэн-2024 амны хөндийн хөтөлбөрөөс /Хэрх, Түнхэл тосгоны ЭМТ-д тус бүр 20,000.0 мянган төгрөгийн, Нэгдсэн эмнэлэгт 36,731.0 мянган төгрөгийн/ нийт **76,731.1** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй шүдний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг Голден мед, Оюудент, Мөнхчулуут өндөр,

Солармед монгол, Ай мед техноложис ХХК зэрэг компаниудаас шууд гэрээ байгуулан худалдан авсан,

- Цахим засаглал бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрөөс нийт **36,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “*Ерөнхий боловсролын 2,5 дугаар сургууль болон 4 дүгээр цэцэрлэгийн гадна, дотор талыг камержуулах*” ажлыг “Бүрэнцэнгэл” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

2. Үйл ажиллагааны батлагдсан төсвөөс шууд худалдан авах босго үнээс давсан дараах төсөл арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ЗДТГ нь **26,126.4** мянган төгрөгийн шатахууны *Шунхлайпетролиум ХХК*, **30,920.2** мянган төгрөгийн тавилга, эд хогшил, **24,833.6** мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдан авах зэрэг үндсэн хөрөнгө, бараа материалын худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, 8 дугаар зүйлийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1: “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг”, 2: “Шууд худалдан авах болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,207.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 99,864.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 86,106.1 мянган төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 85.7 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	3,207.0	2	3,207.0	100.0
Албан шаардлага	6	96,864.8	3	41,118.1	50
Зөвлөмж	13	86,106.1	13	86,106.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>21</b>	<b>186,177.9</b>	<b>18</b>	<b>126,747.7</b>	<b>85.7</b>

ЗДТГ нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд дараах зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, албан хаагчдад хууль, эрх зүйн үндэслэлгүй урамшуулал олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу сумын ЗДТГ-ын дарга Д.Лувсандагва, нягтлан бодогч Т.Цэцэгмаа, Санхүүгийн албаны дарга Б.Энхтуяа нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. ОНХС-ийн эх үүсвэрээр жилийн эцэст малын тэжээлийн нөөц бүрдүүлсэн бөгөөд дараагийн аудитаар уг нөөцийн зарцуулалтыг дараагийн аудитаар үзэх.

2. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас БОХНС арга хэмжээний зарцуулалтыг тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах.

3. ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **51,916.8** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

##### Залруулагдаагүй алдаа:

- ✓ ИТХ нь бараа материалын дансанд зарцуулсан бөгөөд бодитоор оршин байхгүй нийт **15,637.6** мянган төгрөгийн материалыг зарлагдалгүйгээр /ном, аяга, тор, дэвтэр зэрэг 176 ширхэг багц/ үлдэгдлээр тайлагнаж, бараа материалын үлдэгдлийг хий өсгөсөн,

- ✓ ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн **35,500.0** мянган төгрөгийн малын тэжээлийг орлогод авч, бараа материалын дансанд бүртгээгүй,
- ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь шинээр орлогод авсан 3 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдлийн зардлыг тооцоолоогүй, санхүүгийн үр дүнг **779.2** мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Шийдвэрлэлт: 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **92,511.4** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс **13,206.2** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **76,782.0** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **2,523.2** мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

## 5.1 Төлбөрийн акт:

5.1.1. Албан хаагчдын цалин хөлстэй холбоотой нийт **1,336.0** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

✓ Албан хаагчдыг аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд унаа, хоолны хөнгөлөлтийн 1,192.0 мянган төгрөгийг давхардуулан тооцож, олгосон байна. Үүнд:

- ЗДТГ нь 1,088.0 мянган төгрөгийн,
- ИТХ нь 104.0 мянган төгрөгийн.

✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь төрийн сангийн мэргэжилтэн Д.Энхжаргалын төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдлийг бодогдсон цалингаас бус үндсэн цалингаас тооцож 144.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон унаа, хоолны хөнгөлөлтийн болон илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин хууль тогтоомжид заагдаагүй тэтгэмж, урамшуулал олгосон, хувцас худалдан авсан зэрэг нийт **11,870.2** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

✓ Сумын Засаг даргын 2023 оны 01/268 дугаар захирамжаар 2022 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр төрийн сангийн мэргэжилтэн болон харьяа байгууллагуудын нягтлан бодогчдод сарын үндсэн цалинтай тэнцэх нийт 9,950.2 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон. Үүнд:

- Түнхэл тосгоны Захирагчийн алба - 1,752.3 мянган төгрөг,
- Хэрх тосгоны Захирагчийн алба - 2,286.7 мянган төгрөг,
- Сумын ЗДТГ - 4,669.0 мянган төгрөг,
- Ойн анги - 1,242.2 мянган төгрөг.

✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс албан хаагчдад 32 ширхэг нийт 1,920.0 мянган төгрөгийн гар болон сагсан бөмбөгийн, ширээний теннисний тоглолтын хувцас худалдан авсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас авахыг хориглоно”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, эрх зүйн үндэслэлгүй олгосон шагнал урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.1 Албан шаардлага:

**5.2.1.** ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс дараах **15,910.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Мандал сумын Цагдаагийн хэлтэст 20 ширхэг гар станц авахад 7,000.0 мянган төгрөг,
- ✓ “Нээлттэй Сэлэнгэ” арга хэмжээнд оролцох төлөөлөгч, ажлын хэсгийн бүрэлдэхүүний хоол, буудал зэрэг албан томилолтын зардалд 8,910.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь “Урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоодын албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.** Засаг даргын нөөц хөрөнгийн тайлант оны батлагдсан төсвөөс өмнөх оны дараах зардлуудыг санхүүжүүлэхэд нийт **13,207.6** мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Гэр бүлийн үнэ цэнэ болон БНСУ-ын сурагчдын туршлага солилцох сургалтыг зохион байгуулахад 4,811.6 мянган төгрөг,
- ✓ Хэлмэгдэгсдийн үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэхэд 1,667.2 мянган төгрөг,
- ✓ Гавьяатнуудад хүндэтгэл үзүүлэхэд 689.6 мянган төгрөг,
- ✓ Зорилтот бүлгийн хүүхдүүдэд зориулан хүнсний тусламжид 1,423.2 мянган төгрөг,
- ✓ Төрийн албан хаагчдын дархлааг дэмжиж аарц олгоход 1,616.0 мянган төгрөг,
- ✓ Хилийн хамтарсан ажиллагааны шалгалт хийх арга хэмжээнд 3,000.0 мянган төгрөг зэрэг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3 дахь “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулна”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**5.2.3. ИТХ** нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас замын зардлын баримт, гэрээ, хэдэн төлөөлөгч хамрагдсан, үр дүнг тооцсон илтгэх хуудас зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр “Нутгийн удирдлагын холбоо” ТББ-тай хамтран БНХАУ-ын Эрээн-Жининь-Хөх хотод зохиогдсон сургалт, туршлага судлах арга хэмжээнд төлөөлөгчдийг оролцуулсан гэх үндэслэлээр нийт **24,000.0** мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “Үр ашигтай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулан, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.4.** Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, хөтөлбөр хооронд гүйлгэн, зориулалт бусаар нийт **6,095.4** мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

**ЗДТГ:**

- ✓ Бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас хог хаягдал зайлуулах зардалд 573.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх эд

- зүйлс худалдан авахад 305.3 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,613.8 мянган төгрөг, газрын төлбөрт 343.1 мянган төгрөг,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардлаас хог хаягдал зайлуулах зардалд 74.0 мянган төгрөг,
- ✓ БОХНС арга хэмжээний зардлаас Засаг даргын үйл ажиллагааны Эрүүл иргэн-2024 амны хөндийн хөтөлбөрийн зардалд 500.0 мянган төгрөгийг зэрэг нийт **3,409.2** мянган төгрөг,

**Хэрх тосгоны Захирагчийн алба:**

- ✓ Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас урсгал засварын зардалд 2,550.0 мянган төгрөг,
- ✓ Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас газрын төлбөрт 136.2 мянган төгрөг зэрэг нийт **2,686.2** мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.5. ЗДТГ** нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс нийт **17,569.0** мянган төгрөгийн зөрчил гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*”, 15.1.3: “*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*”, 15.1.4: “*...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, ...зэргийг санхүүжүүлэх*”, 15.1.5: “*Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас тухайн байгууллагад тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж байгаа гэх үндэслэлээр 22 албан хаагчид нийт 11,200.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон,
- ✓ Үндсэн үйл ажиллагааны бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-ын зардлаас сэтгүүл, урилга хэвлүүлэхэд 2,649.0 мянган төгрөгийг /сэтгүүл 100 ширхгийг 16250 төгрөгөөр, урилга 200 ширхгийг 5120 төгрөгөөр/, сумын танилцуулга видео хийлгэхэд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс Спирт бал бурам ХК-ийн 50 жилийн ойн арга хэмжээнд 1,720.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн байна.

**5.2.6.** Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар

зарцуулсан болон хууль эрх зүйн үндэслэлгүй урамшуулал олгосон зэрэг зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан сумын ЗДТГ-ын дарга Д.Лувсандагва, Санхүүгийн албаны дарга Б.Энхтуяа, нягтлан бодогч Т.Цэцэгмаа, Хэрх тосгоны Захирагчийн албаны нягтлан бодогч М.Соёл-Эрдэнэ нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***Татварын тайлантай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Тайлант оны эцэст ЗДТГ болон ИТХ нь татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүй нь ХХОАТ-ын өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Татварын хөнгөлөлтийн тооцооллыг бодитоор тооцож, 2023 оны татварын тайланг залруулж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

#### ***Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Зайлшгүй гарах зардлыг төсөвт дутуу тусгаж, төлөвлөсөн буюу төсвийг иж бүрэн, үнэн зөв төлөвлөөгүйгээс дараах байгууллагууд цалингийн зардлаас НДШ-ийн зардалд нийт **2,523.2 мянган** төгрөгийг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ИТХ 193.1 мянган төгрөг,
- Хэрх тосгоны Захирагчийн алба 1,287.5 мянган төгрөг,
- Түнхэл тосгоны Захирагчийн алба 554.2 мянган төгрөг,
- Ойн анги 488.4 мянган төгрөг.

Өгсөн зөвлөмж: Төсвийг хууль, эрх зүйн актад нийцүүлэн бодитоор, үнэн зөв төлөвлөж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	15,637.6			1	15,637.6			1	15,637.6	1	15,637.6
ЗДТГ	1	35,500.0	1	35,500.0					1	35,500.0	1	35,500.0
Түнхэл тосгоны ЗА	1	779.2	1	779.2					1	779.2	1	779.2
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>51,916.8</b>	<b>2</b>	<b>36,279.2</b>	<b>1</b>	<b>15,637.6</b>			<b>3</b>	<b>51,916.8</b>	<b>3</b>	<b>51,916.8</b>

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1								1	4		
ИТХ	3	24,297.1	1	104.0	1	24,000.0	1	193.1				
ЗДТГ	4	57,772.8	1	7,677.0	3	50,095.8						
Хэрх тосгоны Захирагчийн алба	2	6,260.4		2,286.7	1	2,686.2	1	1,287.5				
Түнхэл тосгоны Захирагчийн алба		2450.5		1,896.3				554.2				
Ойн анги		1,730.6		1,242.2				488.4				
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>92,511.4</b>	<b>2</b>	<b>13,206.2</b>	<b>5</b>	<b>76,782.0</b>	<b>2</b>	<b>2,523.2</b>	<b>1</b>	<b>4</b>		

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Худалдан авах ажиллагааны хуулийг хэрэгжүүлээгүй	1	194,611.3			1	194,611.3				
<b>Дүн</b>	1	194,611.3			1	194,611.3				
<b>Нийт дүн</b>	1	194,611.3			1	194,611.3				